



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 04-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Говь ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.3, 6.2.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2019 оны 4 сарын 18-ны Пүрэв гарагийн 10:00 цагт** Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд хуралдуулсугай. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 сарын 28-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2019 оны 3 сарын 11-ний өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2019 оны 3 сарын 13 болон 3 сарын 28-ны өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2019 оны 3 сарын 18-ны өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 3 дугаар хавсралтаараар баталсугай.



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 оны 03 сарын 04-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Долоо. Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна компанийн шуудангийн хаягаар болон брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2019 оны 4 сарын 15-ны өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Н.Сүрэнрагчаа-д даалгасугай.

Комиссын дарга:	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Н.Сүрэнрагчаа
Гишүүд:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ
	Захиргаа, хүний нөөцийн газрын захирал	Ч.Солонго

ТУЗ-ийн ДАРГА		Д.ГЭРЭЛМАА
ТУЗ-ийн ГИШҮҮД		М.БАЯР
		Б.НАНДИН-ЭРДЭНЭ
		Ж.ОЮУНЧИМЭГ
		З.ШАГДАРСҮРЭН
		ТАКЭШИ КАМБЭ
		ХИДЭО САВАДА
		Д.ХУЛАН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 03 сарын 07-ний өдрийн хурлын
05-р тогтоолын 1-р хавсралт



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2076357

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Говь ХК-ийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. 2017 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны ажлын тайланг танилцуулах

**ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ
БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ
ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2019 оны 3 сарын 18-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354), Компанийн цахим хуудас (www.gobi.mn), мөн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж хурлын материалтай танилцаж болно.
2. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Компанийн санхүүгийн жилийн тайлан
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
 - Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх
/Тооллогын комиссын дарга М.Болортуяа/ 3 минут
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 3 минут
3. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
4. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
 - 4.1. Компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
/Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа/ 10 минут
 - 4.2. ТУЗ-өөс компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
 - 4.3. 2017 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
 - 4.4. ТУЗ-ийн 2018 оны ажлын тайланг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
5. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт Хүн тус бүр 3 минут
6. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл: Хүн тус бүр 3 минут
7. Саналын хуудсаар санал авах 10 минут
8. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх 15 минут
9. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах
/Тооллогын комиссын дарга М.Болортуяа/ 5 минут
10. Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.



MONGOLIAN CASHMERE

**"ГОВЬ" ХК-ийн ХУВЬЦАА ЭГЭМШНГҮЙН ЭХДЭНТ
ХҮРЛЫН САНАЛ АВАХ ХҮҮДАС**

"Говь" ХК-ийн хувьцаа эгэмшигчийн хэлэлцэл хурлын өдөр: 2019 оны 04 сарын 18-ны өдөр
Эхэлх цаг: 10:00 цаг
Байршил: "Говь" ХК-ийн Төв газруудын бүрэлдэх "Мяргэж" регистрэн дотроо.

Хуваацаа эгэмшигчийн овог: нэр
Регистрийн дугаар:
Эгэмшигч буй хуваацааны тоо: төгрөг жилийн

№	Шийдвэр гаргаж, батлах асуудлын нэр	Хураас гаргах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзан	Татгалзан тохиролцоод таны өгөх санал
1	Компанийн үйл ажиллагааг бэлэн санхүүгийн таалаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	ТУЗ-ийн дүгнэлт: Өөрсдийн нөөц бололцоог бүрэн дүүргэн ашиглан ажилласан			

2019 оны ... -р сарын ... -ны өдөр

Хуваацаа эгэмшигчийн гарын үсэг:

Тооллогын комисс батлах хэсэг:

Хуваацаа эгэмшигчийн бүртгэлийн дугаар:
Саналын хуудсыг хүчингүйд тооцон тоолсон эсэх: Тийм ☐ Угүй ☐
Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

САНАЛ АВАХ ХҮҮДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Санал авах хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
 - Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол "Зөвшөөрсөн" гэсэн нүдэнд (✓), татгалзан бол "Татгалзан" гэсэн нүдэнд (✓), татгалзан бол Түдэлсэн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
 - Хэрэв та хэтэлж буй асуудлын шийдвэрийн төслийг татгалзан саналтай байгаа бол "Таны өгөх санал" гэсэн нүдэнд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх саналтай байгааг бичнэ.
 - Засаарласан, балласан, (✓)-ээс өөр тэмдэгтлэгэ хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
2. Хэрэв та саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх бол хурлын материалыг танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, өөрийн харицдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар-17062, Шүүдэнгийн хайрмал-36434, "Говь" ХК хаягаар 2019 оны 04 сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
3. Хэрэв та саналаа өөр хүндэр төлөөтүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөн, нотархатаар баталгаажуулсан байна.





Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 03 сарын 04 -ний өдрийн хурлын
05-р тогтоолын 5-р хавсралт

/Хэвлэл мэдээллийн эх/ 076357

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 сарын 18-ны өдрийн 10:00 цагт Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд болох тул хувьцаа эзэмшигч та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2019 оны 3 сарын 28-ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Говь ХК-ийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. 2017 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны ажлын тайланг танилцуулах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2019 оны 3 сарын 18-ны өдрөөс эхлэн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах ТУЗ-ийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс өөрийн харилцдаг брокер, дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер дилерийн компанидаа өгөх эсвэл **Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК** хаягаар 2019 оны 4 сарын 15-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.


Жич: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэл 2019 оны 4 сарын 18-ны 09:20-д эхлэн 10:00 цагт дуусах тул та бүхэн цагтаа цуглана уу.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комиссын дарга Н.Сүрэнрагчаа
Утас: 7013-9977(1002)
Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ
Утас: 7013-9977(1193), 9411-8277
И-мэйл: selenge.m@gobi.mn

Говь ХК-ийн албан ёсны хаяг, байршил:

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК
Утас: 7013-9977, Факс: 7014-3081



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД БЭЛТГЭХ,
ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гүйцэтгэх ажлын утга	Эцсийн хугацаа	Хариуцах эзэн
А. ХУРЛЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ			
1	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан илтгэл, холбогдох шийдвэрийн төсөл	III/11	Д.Гэрэлмаа М.Сэлэнгэ
2	Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэж, хэвлүүлж, тараах	III/18	М.Сэлэнгэ
Б. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ			
1	"Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл"-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх	III/11	М.Сэлэнгэ
2	Хурлын зар мэдээ гаргах, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх	III/13, III/28	М.Сэлэнгэ
3	Хурлын танхимын бэлтгэл, зохион байгуулалт, тоног төхөөрөмжөөр хангах, хурлын хэвийн явцыг хангах	IV/18	Ч.Солонго
4	Хурал дээр хувьцаа эзэмшигчдэд танилцуулах компанийн үйл ажиллагааны талаарх танилцуулга бэлдэх	IV/12	М.Сэлэнгэ
5	Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх компанийн талаарх видео, үзүүлэн бэлдэх	IV/12	М.Бурмаа
6	Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд гарсан дэвшилттэй талыг харуулсан загварын үзүүлэн бэлдэх	IV/12	Б.Болормаа
7	Саналын хуудсыг хэвлүүлэх	III/18	М.Сэлэнгэ
8	Хурлын тэмдэглэл хөтлөх ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл хангуулах	IV/15	Ч.Солонго



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 оны 03 сарын 04-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Тооллогын комисс томилох тухай

Говь ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай:

Комиссын дарга: М.Болортуяа – Үйлдвэрлэл төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга: Н.Сайнзул – Ахлах аудитор
Гишүүд: Ц.Цэцэгбадам – Ахлах нягтлан бодогч
Б.Уянга– Хөдөлмөрийн харилцаа хариуцсан албаны дарга

Хоёр. Тооллогын комисс (М.Болортуяа)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултанд тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Саналын хуудсыг хайрцагаар авах;
6. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
7. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

ТУЗ-ийн ДАРГА.

ТУЗ-ийн ГИШҮҮД.



Д.ГЭРЭЛМАА

М.БАЯР



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20¹⁹ оны ⁰³ сарын ⁰⁷-ны өдөр

Дугаар ⁰⁶

Улаанбаатар хот

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН